



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2025/114/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.Umnugovi@audit.mn

Өмнөговь аймаг

2025 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.02.25

№

130

танай

-ны №

-т

ГУРВАНТЭС СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
П.ОДОНЧИМЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурвантэс сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн хөрөнгийг зохистой удирдаагүйгээс 1,170.0 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн, 326.0 мянган төгрөгийн албан томилолтыг анхан шатны баримтгүй зарцуулсан, 21,000.0 мянган төгрөгийн гэрээний хэрэгжилт тооцоогүй олгосон, 4,680.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7 дэх заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орон нутгийн сонгуулиар шинэ хурлын төлөөлөгчид сонгогдон, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас зохион байгуулсан чадавхжуулах сургалтад хамрагдсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 15 нэр төрлийн 39,564.0 мянга, өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 3 нэр төрлийн 2,600.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 92.4 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,926,308.81</u>	<u>20,438,499.60</u>
34	УРЬДЧИЛГАА	-	12,000,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	12,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6,926,308.81	8,438,499.60
354	Хангамжийн материал	6,926,308.81	8,438,499.60
35410	Бичиг хэргийн материал	527,900.00	1,294,900.00
35420	Аж ахуйн материал	3,593,300.00	4,282,500.00
35440	Түлш, шатах тослох материал	2,805,108.81	2,861,099.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>62,225,708.04</u>	<u>83,490,159.93</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	62,225,708.04	83,490,159.93
392	Биет хөрөнгө	62,225,708.04	72,360,993.24
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,568,290.00	62,993,300.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(9,136,174.79)	(15,064,237.69)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,212,500.00	58,252,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,418,907.17)	(33,820,069.07)
393	Биет бус хөрөнгө	-	11,129,166.69
39301	Програм хангамж	-	11,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(370,833.31)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>69,152,016.85</u>	<u>103,928,659.53</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	<u>1,170,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,170,000.00
413	Өглөг	-	1,170,000.00
4136	Бусад өглөг	-	1,170,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	1,170,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>69,152,016.85</u>	<u>102,758,659.53</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	69,152,016.85	102,758,659.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,459,900.00	9,459,900.00
51101	Өмч: - төрийн	9,459,900.00	9,459,900.00
512	Хуримтлагдсан үр дүн	59,692,116.85	93,298,759.53
51210	Өмнөх үеийн үр дүн	59,692,116.85	59,692,116.85
51220	Тайлант үеийн үр дүн	-	33,606,642.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>69,152,016.85</u>	<u>103,928,659.53</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	290,731,525.00	399,657,279.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	290,731,525.00	399,657,279.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,661,225.00	9,790,779.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,661,225.00	9,790,779.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	252,070,300.00	389,866,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	252,070,300.00	389,866,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	286,894,803.14	400,914,636.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	286,894,803.14	400,914,636.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	226,489,799.06	307,050,198.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	79,064,664.32	151,261,872.25
210101	Үндсэн цалин	40,369,923.35	60,203,313.55
210102	Нэмэгдэл	32,046,440.97	76,887,082.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	922,500.00	5,143,409.10
210104	Урамшуулал	5,725,800.00	9,028,066.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,883,083.02	18,633,184.08
210201	Тэтгэврийн даатгал	6,720,496.46	12,857,259.16
210202	Тэтгэмжийн даатгал	790,646.64	1,512,618.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	632,517.27	775,570.14
210204	Ажилгүйдлийн даатгал	158,129.37	682,138.62
210205	Эрүүл мэндийн даатгал	1,581,293.28	2,805,597.45
2104	Хангамж, бараа материалын зардал	42,806,386.10	16,309,529.21
210401	Бичиг хэрэг	29,531,200.00	3,708,400.00
210402	Тээвэр, шатахуун	10,286,176.10	8,754,229.21
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	765,010.00	1,189,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,224,000.00	1,417,200.00
210408	Бараа материал акталсны зардал	-	1,239,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	185,000.00	-
210604	Урсгал засвар	185,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	7,818,000.00	9,742,000.00
210702	Дотоод албан томилолт	7,818,000.00	9,742,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,201,470.00	78,200,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	51,201,470.00	78,200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,531,195.62	32,903,613.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,850,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,935,399.00	12,004,065.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,745,796.62	20,899,548.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,405,004.08	93,864,437.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,561,225.00	45,362,277.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	12,870,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	14,892,277.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,561,225.00	17,600,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	30,843,779.08	48,502,160.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,843,779.08	48,502,160.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>3,836,721.86</u>	<u>(1,257,357.32)</u>

225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,665,600.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	4,665,600.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(4,665,600.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(828,878.14)</u>	<u>(1,257,357.32)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>290,731,525.00</u>	<u>399,657,279.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	290,731,525.00	399,657,279.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,661,225.00	9,790,779.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,661,225.00	9,790,779.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	252,070,300.00	389,866,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	252,070,300.00	389,866,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>271,731,525.00</u>	<u>390,657,279.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	271,731,525.00	390,657,279.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	211,326,520.92	297,962,841.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	78,878,941.70	151,261,872.25
210101	Үндсэн цалин	40,184,200.73	60,203,313.55
210102	Нэмэгдэл	32,046,440.97	76,887,082.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	922,500.00	5,143,409.10
210104	Урамшуулал	5,725,800.00	9,028,066.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,883,083.02	18,633,184.08
210201	Тэтгэврийн даатгал	6,720,496.46	12,857,259.16
210202	Тэтгэмжийн даатгал	790,646.64	1,512,618.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	632,517.27	775,570.14
210204	Ажилгүйдлийн даатгал	158,129.37	682,138.62
210205	Эрүүл мэндийн даатгал	1,581,293.28	2,805,597.45
2104	Хангамж, бараа материалын зардал	15,350,627.20	16,061,720.00
210401	Бичиг хэрэг	2,572,600.00	4,065,400.00
210402	Тээвэр, шатахуун	11,055,017.20	8,810,220.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	765,010.00	1,189,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	958,000.00	1,996,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	185,000.00	-
210604	Урсгал засвар	185,000.00	-
2107	Томиллолт, зочны зардал	7,818,000.00	9,742,000.00
210702	Дотоод албан томиллолт	7,818,000.00	9,742,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78,425,470.00	90,200,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	78,425,470.00	90,200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,785,399.00	12,064,065.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,850,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,935,399.00	12,064,065.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,405,004.08	92,694,437.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,561,225.00	44,192,277.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	11,700,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	14,892,277.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,561,225.00	17,600,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	30,843,779.08	48,502,160.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,843,779.08	48,502,160.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>19,000,000.00</u>	<u>9,000,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	19,000,000.00	9,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,000,000.00	9,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,000,000.00	9,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,000,000.00	9,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(19,000,000.00)</u>	<u>(9,000,000.00)</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,459,900.00	59,692,116.85	69,152,016.85
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,459,900.00	59,692,116.85	69,152,016.85
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,459,900.00	59,692,116.85	69,152,016.85
D08	Тайлант үеийн үр дүн	-	33,606,642.68	33,606,642.68
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,459,900.00	93,298,759.53	102,758,659.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	389,866,500.00	332,364,339.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	389,866,500.00	332,364,339.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	334,579,500.00	290,632,062.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	148,586,500.00	144,727,846.53
210101	Үндсэн цалин	59,946,400.00	58,897,053.55
210102	Нэмэгдэл	76,956,600.00	76,887,082.92

210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,994,600.00	5,143,409.10
210104	Урамшуулал	5,688,900.00	3,800,300.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,573,200.00	17,836,430.80
210201	Тэтгэврийн даатгал	12,629,800.00	12,301,866.95
210202	Тэтгэмжийн даатгал	1,485,900.00	1,447,278.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	742,900.00	742,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	742,900.00	653,468.48
210205	Эрүүл мэндийн даатгал	2,971,700.00	2,690,916.92
2104	Хангамж, бараа материалын зардал	25,819,800.00	16,061,720.00
210401	Бичиг хэрэг	4,390,000.00	4,065,400.00
210402	Тээвэр, шатахуун	18,181,800.00	8,810,220.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,248,000.00	1,189,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	1,996,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	-
210604	Урсгал засвар	500,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	18,550,000.00	9,742,000.00
210702	Дотоод албан томилолт	18,550,000.00	9,742,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,000,000.00	90,200,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	105,000,000.00	90,200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,550,000.00	12,064,065.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,050,000.00	12,064,065.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,287,000.00	41,732,277.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,287,000.00	41,732,277.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,700,000.00	11,700,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,182,000.00	14,892,277.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,405,000.00	15,140,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	389,866,500.00	341,364,339.83
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	389,866,500.00	341,364,339.83
132001	Орон нутгийн төсвөөс	389,866,500.00	341,364,339.83

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,790,779.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,790,779.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,330,779.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,534,025.72
210101	Үндсэн цалин	1,306,260.00
210104	Урамшуулал	5,227,765.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	796,753.28
210201	Тэтгэврийн даатгал	555,392.21
210202	Тэтгэмжийн даатгал	65,340.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	32,670.14

210204	Ажилгүйдлийн даатгал	28,670.14
210205	Эрүүл мэндийн даатгал	114,680.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,460,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,460,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,460,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,790,779.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,790,779.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,790,779.00

Гурав. Аудитын илрүүлэлт: Аудитаар нийт 16,658.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн үр дүнгийн тайланг бараа материалын тодруулга тайлантай тулгахад 1,239.8 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлогыг тодруулга тайлангаас 1,700.0 мянга, бичиг хэргийн зардлыг 30.0 мянган төгрөгөөр зөрүүтэй
- Цалингийн өглөгийн бүртгэлийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн цалин хөлс болон нэмэгдэл урамшлаас 1,658,6 мянган төгрөгөөр зөрүүтэй
- Бараа материалын орлогыг мөнгөн гүйлгээний тайлантай тулгахад бичиг хэргийг 30.0 мянган төгрөгийг дутуу орлогодсон,
- "Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэрээ"-г 1 жилээр байгуулж 12,000.0 мянган төгрөгийг шууд зардлаар бүртгэсэн нь УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгааг залруулав.

Аудитаар илэрсэн нийт 34,324.4 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлж 1,176.0 мянган төгрөгт төлбөрийн акт, 26,850.0 мянган төгрөгт албан шаардлага, 1,298.0 мянган төгрөгийн зөвлөмж өглөө.

3.2 Төлбөрийн акт

1. Нөөц сангийн хөрөнгөөс эмчилгээ болон сургалтын зардал, суварга бүтээх ажлын дэмжлэгээс 850.0 мянган төгрөгийн албан татвар суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар,...", Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дугаар тушаалын хавсралт "Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2-д "Суутган төлөгч нь хууль тогтоомжид тусгайлан заагаагүй "Хөдөлмөрийн дотоод журам" зэрэг зөвхөн тухайн байгууллагын баримт бичиг, шийдвэрийг үндэслэн олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламжийг албан татвараас чөлөөлөхгүй" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2. Албан томилолтоор ажилласан 3 ажилтанд 326.0 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.2 Албан шаардлага

1. Төсвийг зохистой удирдаж ажиллаагүйгээс тайлант онд 1,170.0 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

2. Сумдын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны нэгдсэн арга хэмжээнд бэлэг дурсгал, хүлээн авалтын зардалд 4,680.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3. "Гэрэлт цагаан дагина" ТББ-тай 21,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгэл нь хөтөлбөрийн дагуу зарцуулагдсан эсэх нотлогдохгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7 "худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлогын 5,000,000 төгрөгийн гүйлгээ мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 "Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Албан томилолтыг анхан шатны баримттай тулгахад томилсон хоног бичээгүй байхад 1,298.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтыг сайжруулж төсвийн хөрөнгийн үр ашигтай зарцуулахад анхаарч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Санхүүгийн үр дүнгийн тайланг бараа материалын тодруулга тайлантай тулгахад 1,239.8 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлогыг тодруулга тайлангаас 1,700.0 мянга, бичиг хэргийн зардлыг 30.0 мянган төгрөгөөр зөрүүтэй	3	2,969.8			3	2,969.8	3	2,969.8				
2	Цалингийн өглөгийн бүртгэлийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн цалин хөлс болон нэмэгдэл урамшлаас 1,658,6 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	1,658.6			1	1,658.6	1	1,658.6				
3	Бараа материалын орлогыг мөнгөн гүйлгээний тайлантай тулгахад бичиг хэргийг 30.0 мянган төгрөгийг дутуу орлогодсон	1	30.0	1	30.0			1	30.0				
4	"Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэрээ"-г 1 жилээр байгуулж 12,000.0 мянган төгрөгийг шууд зардлаар бүртгэсэн	1	12,000.0			1	12,000.0	1	12,000.0				
	Дүн	6	16,658.4	1	30.0	6	16,628.4	6	16,628.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Нөөц сангийн хөрөнгөөс эмчилгээ болон сургалтын зардал, суварга бүтээх ажлын дэмжлэгээс 850.0 мянган төгрөгийг албан татвар суутгаагүй	1	850.0	1	850.0								
2	Албан томилолтоор ажилласан 3 ажилтанд 326.0 мянган төгрөгийг илүү тооцож олгосон	1	326.0	1	326.0								
3	21.0 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгэл нь хөтөлбөрийн дагуу зарцуулагдсан эсэх нотлогдохгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон	1	21,000.0			1	21,000.0						

4	Төсвийг зохистой удирдаж ажиллаагүйгээс тайлант онд 1,2 сая төгрөгийн өглөг үүсгэсэн	1	1,170.0			1	1,170.0						
5	Сумдын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны нэгдсэн арга хэмжээнд бэлэг дурсгал, хүлээн авалтын зардалд 4.7 сая төгрөг зарцуулсан	1	4,680.0			1	4,680.0						
6	Албан томилолтыг анхан шатны баримттай тулгахад томилсон хоног бичээгүй байхад 1.3 сая төгрөг олгосон	1	1,298.0					1	1,298.0				
	Дүн	6	29,324.0	2	1,176.0	3	26,850.0	1	1,298.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
1	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлогын 5,0 сая төгрөгийн гүйлгээ мэдээлээгүй	1	5,000.0			1	5,000.0						
	Дүн	1	5,000.0			1	5,000.0						
	НИЙТ ДҮН	7	34,324.0	2	1,176.0	4	31,850.0	1	1,298.0				

